АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/149/-НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор П.Энхжаргал<br>Утас: 9974-3112<br>Цахим хаяг: EnkhjargalP@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт ....... 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 8
3. Аудитын тайлан ....... 8
3.1 Ерөнхий зүйл ....... 8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 9
3.4 Материаллаг байдал ....... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 12
3.8 Аудитын гол асуудал ....... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....... 12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....... 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 13
4. Аудитын илрүүлэлт ....... 13
4.1 Албан шаардлага ....... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.БАТБААТАР ТАНАА

2022.02.25 № 104
танай ____________-ны № ______________-т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,201,366.00** | **43,895,000.00** |
| **33** | **АВЛАГА** | **4,177,366.00** | **0.00** |
| **33500** | **Бусад авлага** | **4,177,366.00** | **0.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 4,177,366.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **14,024,000.00** | **43,895,000.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **2,310,000.00** | **5,060,000.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,310,000.00 | 5,060,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **11,714,000.00** | **38,835,000.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 48,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,121,000.00 | 20,346,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,222,000.00 | 18,441,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 371,000.00 | 0.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,543,302,320.82** | **16,097,526,793.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **17,543,302,320.82** | **16,097,526,793.75** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **17,542,064,820.82** | **16,096,289,293.75** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 56,155,156.61 | 56,155,156.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -12,487,354.32 | -16,440,418.62 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 838,195,000.00 | 899,715,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -719,268,476.82 | -742,240,144.42 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,705,158.00 | 9,605,058.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,746,757.74 | -2,522,758.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,121,251,868.22 | 26,218,069,568.22 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -8,747,739,773.13 | -10,326,052,168.04 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,237,500.00** | **1,237,500.00** |
| 39301 | Програм хангамж | 1,237,500.00 | 1,237,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **17,561,503,686.82** | **16,141,421,793.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **17,561,503,686.82** | **16,141,421,793.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **17,561,503,686.82** | **16,141,421,793.75** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,121,259,190.81 | 2,121,259,190.81 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **15,412,497,138.40** | **13,992,637,385.33** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 15,412,497,138.40 | 15,412,719,278.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -1,420,081,893.07 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 27,747,357.61 | 27,525,217.61 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **17,561,503,686.82** | **16,141,421,793.75** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,078,665,260.97** | **1,040,059,781.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **484,669,492.70** | **255,996,081.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **484,669,492.70** | **255,996,081.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **484,669,492.70** | **255,996,081.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 484,669,492.70 | 255,996,081.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **593,995,768.27** | **784,063,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **432,531,068.27** | **3,349,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 424,943,200.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,587,868.27 | 3,349,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **161,464,700.00** | **780,714,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 161,464,700.00 | 721,047,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 59,667,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,105,631,323.87** | **2,451,536,594.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,105,631,323.87** | **2,451,536,594.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,097,161,637.87** | **2,423,109,694.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **304,325,411.00** | **412,130,500.00** |
| 210101 | Үндсэн цалин | 304,325,411.00 | 412,130,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,040,653.00** | **55,637,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,867,644.00 | 39,152,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,043,252.00 | 4,121,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,434,602.00 | 3,297,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 608,650.00 | 824,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,086,505.00 | 8,242,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,534,500.00** | **2,150,000.00** |
| 210302 | Түлш, халаалт | 2,534,500.00 | 2,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,111,550.00** | **3,377,400.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 907,200.00 | 2,737,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 609,000.00 | 640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,595,350.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,026,500.00** | **3,662,620.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,026,500.00 | 3,662,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **52,681,495.00** | **49,519,155.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,198,800.00 | 4,607,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,462,100.00 | 4,906,180.00 |
| 210604 | Урсгал засвар | 48,020,595.00 | 40,005,775.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,221,831.17** | **13,580,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,494,642.00 | 10,810,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 1,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,240,355.00 | 520,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 434,000.00 | 250,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 52,834.17 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,671,219,697.70** | **1,883,052,419.07** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 160,104,565.00 | 187,985,991.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,511,115,132.70 | 1,695,066,428.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,469,686.00** | **28,426,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,469,686.00** | **28,426,900.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,736,000.00 | 3,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,691,686.00 | 25,426,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,042,000.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-2,026,966,062.90** | **-1,411,476,813.07** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.00** | **8,605,080.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.00 | 8,605,080.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-2,026,966,062.90** | **-1,420,081,893.07** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,747,357.61** | **17,439,463,201.30** | **19,588,469,749.72** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,747,357.61** | **17,439,463,201.30** | **19,588,469,749.72** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-2,026,966,062.90** | **-2,026,966,062.90** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,747,357.61** | **15,412,497,138.40** | **17,561,503,686.82** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,747,357.61** | **15,412,497,138.40** | **17,561,503,686.82** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 222,140.00 | 222,140.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,747,357.61** | **15,412,719,278.40** | **17,561,725,826.82** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -222,140.00 | 0.00 | -222,140.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -1,420,081,893.07 | -1,420,081,893.07 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **2,121,259,190.81** | **27,525,217.61** | **13,992,637,385.33** | **16,141,421,793.75** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **593,995,768.27** | **780,714,700.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **593,995,768.27** | **780,714,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **432,531,068.27** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 424,943,200.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,587,868.27 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **161,464,700.00** | **780,714,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 161,464,700.00 | 721,047,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 59,667,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **596,374,457.17** | **778,814,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **596,374,457.17** | **778,814,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **588,294,771.17** | **750,387,900.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **304,325,411.00** | **412,130,500.00** |
| 210101 | Үндсэн цалин | 304,325,411.00 | 412,130,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,040,653.00** | **55,637,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,867,644.00 | 39,152,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,043,252.00 | 4,121,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,434,602.00 | 3,297,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 608,650.00 | 824,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,086,505.00 | 8,242,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,984,500.00** | **3,500,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 1,984,500.00 | 3,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,278,650.00** | **3,500,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 907,300.00 | 2,734,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 640,000.00 | 766,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,731,350.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **5,502,200.00** | **6,500,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,502,200.00 | 6,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **53,998,312.00** | **54,049,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,970,700.00 | 7,100,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,180,600.00 | 6,448,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 47,847,012.00 | 40,500,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,835,714.17** | **15,770,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,107,825.00 | 13,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 1,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,241,055.00 | 520,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 434,000.00 | 250,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 52,834.17 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **165,329,331.00** | **199,300,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,329,331.00 | 199,300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,079,686.00** | **28,426,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,079,686.00** | **28,426,900.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,288,000.00 | 3,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,691,686.00 | 25,426,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-2,378,688.90** | **1,899,900.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **750,000.00** | **1,899,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **750,000.00** | **1,899,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **750,000.00** | **1,899,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 750,000.00 | 1,899,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-750,000.00** | **-1,899,900.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-3,128,688.90** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,128,688.90 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **780,714,700.00** | **780,714,700.00** | **0.00** | **100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **780,714,700.00** | **780,714,700.00** | **0.00** | **100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **752,287,800.00** | **752,287,800.00** | **0.00** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **412,130,500.00** | **412,130,500.00** | **0.00** | **100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 412,130,500.00 | 412,130,500.00 | **0.00** | **100.00** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **55,637,600.00** | **55,637,600.00** | **0.00** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,152,400.00 | 39,152,400.00 | **0.00** | **100.00** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,121,300.00 | 4,121,300.00 | **0.00** | **100.00** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,297,000.00 | 3,297,000.00 | **0.00** | **100.00** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 824,300.00 | 824,300.00 | **0.00** | **100.00** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,242,600.00 | 8,242,600.00 | **0.00** | **100.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,500,000.00** | **3,500,000.00** | **0.00** | **100.00** |
| 210302 | Түлш, халаалт | 3,500,000.00 | 3,500,000.00 | **0.00** | **100.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,500,000.00** | **3,500,000.00** | **0.00** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,800,000.00 | 2,734,000.00 | **-934,000.00** | **65.84** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,700,000.00 | 766,000.00 | **934,000.00** | **221.93** |
| **2105** | **Нормативт зардал** | **6,500,000.00** | **6,500,000.00** | **0.00** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,500,000.00 | 6,500,000.00 | **0.00** | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **55,949,700.00** | **55,949,700.00** | **0.00** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 9,000,000.00 | **0.00** | **100.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,448,800.00 | 6,448,800.00 | **0.00** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 40,500,900.00 | 40,500,900.00 | **0.00** | **100.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,770,000.00** | **15,770,000.00** | **0.00** | **100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,000,000.00 | 13,000,000.00 | **0.00** | **100.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | **100.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 1,500,000.00 | **0.00** | **100.00** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 520,000.00 | 520,000.00 | **0.00** | **100.00** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 250,000.00 | **0.00** | **100.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **199,300,000.00** | **199,300,000.00** | **0.00** | **100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 199,300,000.00 | 199,300,000.00 | **0.00** | **100.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,426,900.00** | **28,426,900.00** | **0.00** | **100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **28,426,900.00** | **28,426,900.00** | **0.00** | **100.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 | **0.00** | **100.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,426,900.00 | 25,426,900.00 | **0.00** | **100.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **780,714,700.00** | **780,714,700.00** | **0.00** | **100.00** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **780,714,700.00** | **780,714,700.00** | **0.00** | **100.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 721,047,500.00 | 721,047,500.00 | **0.00** | **100.00** |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 59,667,200.00 | 59,667,200.00 | **0.00** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **36.00** | **36.00** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | **0.00** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 4.00 | 4.00 | **0.00** | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 31.00 | 31.00 | **0.00** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,349,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,349,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,349,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,872,000.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,872,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **917,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 917,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **560,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 560,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,349,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,349,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,349,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газар нь Хот тохижилт үйлчилгээний газар нь гудамж, талбайн хог хаягдал, цас цэвэрлэдэг үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 онд дэвшүүлсэн зорилго, зорилт нь: Засаг захиргаанаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэхийн тулд:

- Аймгийн төвийн 6 багт сар бүр хүрч үйлчлэх авто машины бүрэн бүтэн байдлыг хангах,сум аймагт уламжлан авто машины парк шинэчлэлт хийлгэх
- Цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг улам сайжруулах
- Гудамж талбайн нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн асалтын хугацааг уртасган асахгүй чиглэлийн гэрэлтүүлгийг засварлан асаах
- Байгууллагын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар аймаг орон нутгийн удирдлагад хандаж төсвийг шийдвэрлүүлэх
- Ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээ оношилгоонд хамруулах
- Ажилчдын дархлааг дэмжиж байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан эмийн болон хүнсний дэмжлэг үзүүлэх
- Нэгдсэн хогийн цэгийг цэгцтэй байлгах орон нутгийн удирдлагуудад хандан 8 жилийн нөөц нь дууссан талбайг дахин шинэчилж байгуулах
- Онгоцны буудлын эзэнгүй үүссэн хогийг дарж булах
- Ногоон байгууламжийг сэргээн тордох
- Нийтийн эзэмшлийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах нь Цэцэрлэг хотын өнгө төрхийг дээшлүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 780.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1,420.1 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 | |
| Авлага | 4.2 | - | -4.2 | -100.0 |
| Бараа материал | 14.0 | 43.9 | 29.9 | 213.6 |
| Үндсэн хөрөнгө | 17,543.3 | 16,097.5 | -1445.8 | -8.2 |
| **Нийт хөрөнгө** | **17,561.5** | **16,141.4** | **-1420.1** | **-8.1** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 17,561.5 | 16,141.4 | -1420.1 | -8.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **17,561.5** | **16,141.4** | **-1420.1** | **-8.1** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Авлагыг бүрэн барагдуулсан байна.*

Авлагын данс нь 4.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсныг тайлант онд бүрэн барагдуулан ажилласан байна.

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2 дахин өссөн байна.*

Бараа материалын данс нь 14.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 211.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 181.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 43.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын үлдэгдэл дүн 29.9 сая төгрөгөөр өссөн нь 7 сард гудамны гэрэлтүүлгийн сэлбэгийн захиалга хийгээд хил хаагдсантай холбоотойгоор 10 сард ирж зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 8.2 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 17,543.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.9 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 256.0 сая, нийт 257.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 1,695.1 сая төгрөгийн, элэгдүүлж дуусаагүй үндсэн хөрөнгө акталсантай холбоотойгоор 8.6 сая төгрөгийн зардал гарч, 16,097.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Засгийн газрын хувь оролцоо 8.1 хувиар буурсан байна.*

Цэвэр  хөрөнгө өмчийн дүн 16,141.4 сая төгрөг болж 1,420.1 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 492.2 | 256.0 | -236.2 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 161.5 | 721.0 | 559.5 |
| Нэмэлт санхүүжилт | 365.3 | 3.3 | -362 |
| Орон нутгийн төсвөөс | 59.7 | 59.7 | 0 |
| **Үйл ажиллагааны орлого** | **1078.7** | **1040.0** | **-38.7** |
| Цалин, шимтгэлийн зардал | 342.4 | 467.8 | 125.4 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 69.3 | 58.6 | -10.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14.2 | 13.6 | -0.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2671.2 | 1883.1 | -788.1 |
| Урсгал шилжүүлэг | 8.5 | 28.4 | 19.9 |
| **Үйл ажиллагааны зардал** | **3105.6** | **2451.5** | **-654.1** |
| **Үнэ төлбөргүй гарсан зардал** | | **8.6** | **8.6** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-2026.9** | **-1420.1** | **606.8** |

Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 38.7 сая төгрөг буюу 3.6 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын хэмжээтэй холбоотой байна.Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж  ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 784.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 4.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 780.7 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 780.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 780.7 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого буюу нохой устгалын орлого болох 3.3 сая

төгрөгийг төвлөрүүлэн нормын хувцас худалдан авах 1.9 сая төгрөг, урсгал засварын зардалд 0.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжаар Орон нутгийн өмчийн газраас 194.5 сая төгрөгийн хогийн нэгдсэн цэгт хог дахин боловсруулах тоног төхөөрөмж, 58.5 сая төгрөгийн хогийн машин, 3.0 сая төгрөгийн “Портер” маркын автомашин нийт 256.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 84.2 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 780.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 780.7 сая төгрөгийг зарцуулж, 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 113.0 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Суудлын автомашин байхгүй.
- Тайлант онд төсвийн хэмнэлт бий болгоогүй байгаа тул нийт 780.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 412.1 сая төгрөгийн үндсэн цалин, 55.6 сая төгрөгийн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 25.4 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал нийт 287.3 сая төгрөгийн 10% буюу 28.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажиллах ёстой байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Хот тохижилт үйлчилгээний газар нь 2021 онд нийт 120.1 сая төгрөгийн 127 мэдээлэхээс 112 мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлсэн хэдий ч 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, 12 мэдээллийг огт мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ*

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тус байгууллага нь төсвийн хэмнэлт бий болгоогүй байгаа тул нийт 780.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 412.1 сая төгрөгийн үндсэн цалин, 55.6 сая төгрөгийн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 25.4 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал нийт 287.3 сая төгрөгийн 10% буюу 28.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажиллах ёстой байна.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д заасан "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг Хот тохиэилт үйлчилгээний газрын даргын 2021.06.14-ны 29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шатахуун зарцуулалтыг нягтлан үзэх шаардлагатай гэж үзлээ.

## <u>4. Аудитын илрүүлэлт</u>

Аудитаар нийт 30.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн хэдий ч 28.7 сая төгрөгийн хэмнэлттэй холбоотой алдаа, зөрчил нь материаллаг бус тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Албан шаардлага

Аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт зохицуулалт хийлгүйгээр бараа үйлчилгээний зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан 1.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор батлагдсан " Төсвийн хэмнэлтийн тухай авах зарим арга хэмжээ"-ний **1.4** "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад.....албан конторын тавилга, ...... тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын **2.1.1,** 2019 оны 74-р тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журмын **5.3** дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

-----оОо-----

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | |
| 1 | ХТҮГ | 1 | 1.9 | 1 | 1.9 | 0 | 0 |
| Дүн | | 1 | 1.9 | 1 | 1.9 | 0 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | |
| 1 | ХТҮГ | 2 | 28.7 | 1 | 28.7 | 1 | 0 |
| Дүн | | 2 | 28.7 | 1 | 28.7 | 1 | 0 |
| Нийт дүн | | 3 | 30.6 | 2 | 30.6 | 1 | 0 |